

Цахим орчин дахь сэтгэгдэл нь иргэний сэтгүүл зүйн илрэл болох нь

Удирдагч: М.Зулькафиль (доктор (Sc.D), МУСГЗ)

Гүйцэтгэсэн: Д.Ганзориг (МУИС-ийн Сэтгүүл зүйн

III ангийн оюутан)

- “Глоб Интернэшнл” байгууллагаас зохион байгуулж буй судалгааны шилдэг бүтээлийн уралдаанд

Түлхүүр үг: Цахим хэвлэл, иргэний сэтгүүл зүй, нэрээ нууцлах эрх, цахим эрх чөлөө, сэтгэгдэл

Зуун жилийн түүхтэй Монголын сэтгүүл зүйн салбар өдөр ирэх тусам хөгжин дэвжсээр байна. Шинээр хэвлэл мэдээллийн хэрэгслүүд байгуулагдан, иргэдийн мэдээлэл олж авах боломж, эх сурвалж улам нэмэгдэж байгаа нь сайшаалтай. “Орчин үед мэдээллийн ач холбогдол эрс өсөн нэмэгдэж, энерги матери хэмээх ойлголтуудтай адилтган үздэг болжээ. Үүнээс үзэхэд хүн төрөлхтний амьдралд үнэн бодитой мэдээллийн үнэ цэнэ, үүрэг үнэлж баршгүй чухал гэдэг нь ойлгомжтой”¹.

“2013 оны нэгдүгээр улирлын байдлаар манайд 555 хэвлэл мэдээллийн хэрэгсэл үйл ажиллагаа явуулж байв. Эдгээрийн дотроос Монголын сайтуудын холбоо, сайтуудын ассоциацид бүртгэлтэй, өөрийн гэсэн редакцитай 68 сайт байна.”² Судалгааны дүнгээс ажиглахад, хэдийгээр иргэдийн мэдээлэл хүлээн авдаг гол эх сурвалж нь телевиз боловч түүнтэй эн зэрэгцэхүйц ач холбогдолтой, чухал суваг нь интернэт болж байна. Ингэснээр интернэтээр дамжуулаад иргэдийн мэдээлэл солилцох, олж авах, үзэл бодлоо илэрхийлэх боломж бололцоо бүрэлдэн тогтож байгаа юм.

¹ Зулькафиль М. Орчин үеийн сэтгүүл зүй. УБ 2009.х.21

² Монголын хэвлэлийн хүрээлэн. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн мониторингийн судалгаа. УБ 2013.х.1

Цахим хэвлэл буюу интернэт нь өнөө үед буй хамгийн шуурхай мэдээллийн хэрэгсэл болохын хувьд иргэдийн санал хүсэлт, дуу хоолойг төрд хүргэх, улс оронд болж буй аливаа асуудалд олон ургальч байдлаар хандах, байр сууриа илэрхийлэх боломж олгож байгаагаараа ихээхэн ач холбогдлыг сэтгүүл зүйн салбар төдийгүй нийгмийн хүрээнд үзүүлж байна. Нэг ёсондоо “мэдээллийн төдийгүй харилцааны үүргийг нэгэн зэрэг агуулж байдгаараа маш том нөлөөг үзүүлдэг”³ хүчирхэг хэрэгсэл гэж хэлж болно. Тэгэхээр энэ нь нэг талаараа иргэдэд мэдээлэл өгч, нөгөө талаараа тэдний дуу хоолойг илүү хүртээмжтэй, шуурхай байдлаар хүргэх, нийгмийн амьдралд татан оролцуулах эргэх холбоог үүсгэж байна. Үүнийг сэтгүүл зүй судлалд “Иргэний сэтгүүл зүй” гэдэг. Доктор Л.Норовсүрэн өөрийн нэг сэдэвт бүтээлдээ “Иргэний сэтгүүл зүй нь нэг талаас ХМХ-ээс амьдралын гүн рүү тавих анхаарлаа нэмэгдүүлж, жирийн иргэдийн ахуй амьдралыг илүү тусгах үйл ажиллагаа, нөгөө талаас хэвлэл мэдээллийн үйл ажиллагаанд өргөнөөр татан оролцуулах явдал юм”⁴ гэж тодорхойлжээ. Эндээс бид Монголын сэтгүүл зүй, ялангуяа иргэний сэтгүүл зүй хөгжихөд хамгийн ойр, чухал нөлөөтэй салбар бол өнөө үед ХМХ-үүд дундаас цахим хэвлэл болж байна гэж дүгнэх саналтай байна.

Иргэний сэтгүүл зүй хөгжих, иргэдийн оролцоо нэмэгдэхэд цахим орчин чухам яаж нөлөөлөөд байна вэ гэдэг асуудал эндээс урган гарч ирнэ. Яаж?, Яагаад?

Хүмүүс өдөр тутам интернэтээр аялж, янз бүрийн нийгмийн сүлжээнд холбогдож байна. Ялангуяа, фэйсбүүк, твиттерээр өөрийн санал сэтгэгдлээ бичин дэлхийн аль ч өнцөг булан бүрт буй хүмүүстэй харилцаж байдаг. Ингэхдээ голдуу сэтгэгдэл (comment)-ээр дамжуулаад үзэл бодлоо илэрхийлж буйг онцлууштай. “Иргэдийн сэтгэгдлээс санаа авах зүйлс их байдгаас гадна иргэний сэтгүүл зүйн үндэс эндээс

гарах сайн талтай гэж барууны сэтгүүл зүйд үзэх болсон”⁵ нь үүний нэгэн баталгаа, илрэл нь юм. Тийм ч учраас өөрийн үзэл бодлоо сэтгэгдлээр байнга, идэвхтэй илэрхийлдэг иргэдийг иргэний сэтгүүл зүйн хөгжилд сайн нөлөө болж

³ Болд-Эрдэнэ Б. Интернэт сэтгүүл зүй. УБ 2009.х.9

⁴ Норовсүрэн Л. Энхтуяа Х. Иргэний сэтгүүл зүй. УБ 2005.х.5

⁵ МУИС. “Сэтгүүл зүй” эрдэм шинжилгээний бичиг. УБ 2010х.55

буйг онцлон тэмдэглэх хэрэгтэй. Түүнчлэн мэдээллийн сайтуудад өөрийн бичсэн нийтлэлээ байршуулж, тодорхой хүрээний уншигчидтай болсон, нөлөө бүхий нийтлэлчдийг ч \мэргэжлийн бус хүмүүс\ иргэний сэтгүүл зүйн нэгээхэн хэсэг гэж үзэхэд буруудахгүй юм.

Үнэхээр иргэний сэтгүүл зүй хөгжихөд иргэдийн сэтгэгдэл хир зэрэг түлхэц болж байгаа юм бол?. Цахим эрх чөлөө Монголд хэр зэрэг байна вэ?. Иргэний сэтгүүл зүйн хөгжилд интернэт чухам ямар байдлаар нөлөөлж байна вэ?. Бид үүнийг судалгааныхаа гол сэдэвтэй уялдуулан авч үзэж, олон талаас харж нэгтгэн дүгнэхийг зорилоо.

Иргэний сэтгүүл зүй цахим орчинд хөгжиж байна гэдгээс шууд иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний асуудал сөхөгдөнө. Мөн хууль эрх зүйн орчин хир зэрэг байна вэ гэдэг нь нэн чухал юм. Монгол улсын үндсэн хуулийн 16-р зүйлийн 16 дахь хэсэгт "...Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх хэвлэн нийтлэх эрхтэй"⁶ гэж заасан байдаг. Мөн Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19 дүгээр зүйл, Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын факт зэрэг эрх зүйн баримт бичгүүдээр иргэн хүн хаана ч, хэзээ ч өөрийн үзэл бодлоо илэрхийлэх эрхтэйг баталгаажуулж өгсөн нь бий. "Манай улсад 2011 онд мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах тухай хууль гарснаар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө эрх зүйн хувьд баталгаажсан"⁷. Гэхдээ Монголд үйлчилж буй энэ хууль дүрэм нь үндсэн хуультай зөрчилдөх зэрэг асуудал байгаа юм. БНАСАУ, БНХАУ зэрэг дэлхийн зарим оронд иргэд нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөгүй байдаг. Гэтэл манай улсад үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө эрх зүйн хувьд

баталгаажсан боловч хагас чөлөөт хэвлэлт орны багтаж яваа нь хуулийн орчинд асуудал байгаагийн тод илрэл юм. Уг нь манай улсын ихэнх сум суурин газар интернэтэд холбогдож хот хөдөөгийн иргэдийн мэдээлэл хүлээн авах, цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх боломж ялгалгүй болсон гэхэд болно. Гэвч иргэд үзэл бодлоо илэрхийлж "иргэн-сэтгүүлч" болох боломжинд саад учирч байгаа нь бодит байдал юм.

⁶ www.legalinfo.mn

⁷ Азийн хэвлэл мэдээллийн барометр. УБ 2012.х.10

Иргэд өөрийн үзэл бодлоо цахим орчинд чөлөөтэй илэрхийлж, харилцан мэдээлэл солилцох замаар Иргэний сэтгүүл зүй хөгжиж байгааг бид дээр онцолсон. Гэтэл Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарласан алхмыг Засгийн газраас хийсэн. “Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 1-р сарын 5-ны өдрийн 1-р тогтоолоор “Цахим хуудас дахь сэтгэгдлийн нэгдсэн систем” баталж, 100 гаруй хориотой үгсийн жагсаалтыг гаргасан”⁸. Энэ бол үзэл бодлоо илэрхийлэхдээ цахим орчинд соёлтой байж, бусдыг гүтгэж доромжлохгүй байхыг сануулсан төрийн зүгээс хийж буй хүчтэй хаалт юм. Хэрвээ цахим орчинд ёс зүйгүй авирлавал нэг талаар иргэдийн сэтгэгдлээр дамжуулан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө хумигдана. Нөгөө талаараа, бидний дэвшүүлэн тавьж буй иргэний сэтгүүл зүй цахим орчноор дамжуулан хөгжих боломж хязгаарлагдаж болохыг харуулсан том сургамж юм. Энд хэлэх гэсэн гол санаа нь бид нэг нэгэндээ цахим орчинд хүндэтгэлтэй соёлтой хандаж сурвал эрх чөлөө баталгаажна. Харин эсрэгээр бол цахим эрх чөлөө улам хумигдах аюул буйг сануулсан явдал юм.

Бид судалгааны бүтээлээ зөвхөн өөрийн орны жишиг, жишээн дээр дөрөөлөн авч үзэх нь дэндүү учир дутагдалтай юм. Иймд дэлхийн бусад орнуудад энэ талын эрх зүйн орчин ямар байдгийг эрж хайж үзлээ.

НҮБ болон олон улсын байгууллагууд цахим эрх чөлөөг хязгаарлахгүй байх, энэ нь маш олон хууль дүрмийг зөрчдөг болохыг онцолж, эрх, эрх чөлөөгөөр хангах талаарх үзэл баримтлалыг дэлхий нийтээр тунхаглан зарладаг.

Харамсалтай нь

“Цахим орчин дахь эрх чөлөөний хязгаарлалт нь зарим ардчилсан бус оронд хийгддэг байна. Тухайлбал, “Иран улс Барууны гаж соёлыг гэтлэх ажлын хүрээнд “Wikipedia”, “Youtube” зэрэг нийгмийн түгээмэл сайтуудад нэвтрэх хэрэглэгчдийнхээ эрхийг 2006 оны 12 сарын 3-наас хааж эхэлжээ.”⁹ Энэ мэт цахим эрх чөлөөг хязгаарлах гэсэн оролдлого байнга хийгддэг нь улс орнууд, ялангуяа интернэт хэрэглэгчид өөрсдөө нэгэн зэрэг эрх чөлөөний төлөө

⁸ Цэрэнжав Д. “Интернэт, олон нийтийн өргөн нэвтрүүлэг, иргэний нийгмийн оролцоо” илтгэл. УБ 2013

⁹ www.securitylab.ru/news/215636.php

боловсон аргаар, соёлтойгоор тэмцэх цаг болсныг харуулж байна. Хамгийн аюултай гэж үзэж болохоор нэг зүйл нь “дэлхийн олон оронд интернэт дэх мэдээллийг хязгаарлаж блоклохдоо тэд цензур хэмээх үг хэрэглэхээс аль болохоор зайлсхийдэг бөгөөд интернэт-шүүлтүүр гэж ямар нэг сөрөг өнгө аясгүй үгээр нэрлэдэг”¹⁰ явдал юм. Гэхдээ хөгжингүй, сэтгүүл зүйн салбар маш сайн батжин тогтсон, хэвлэлийн эрх чөлөөг дээдэлдэг орнуудад интернет дэх сэтгэгдэл, өгөгдөл зэрэгт шүүлт хийх, агуулгын хязгаарлалт хийж хорих шаардлагагүй гэж үздэг байна. Өөрөөр хэлбэл, цахим эрх чөлөөг хангаж, иргэдийнхээ үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг нь баталгаажуулахад чиглэж байна. Түүнчлэн иргэдээ сэтгүүл зүйн төвд тавьж иргэний сэтгүүл зүйг хөгжүүлэхэд анхааран ажилладаг байна.

Манай улс ч ардчилсан орон болохын хувьд цахим орчинд үзэл бодлоо саадгүй илэрхийлэх эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, улам “дархлаажуулах” ажлыг хийж байна. Гэхдээ энэ ажилд Монголын сэтгүүлчдийн эвлэл, Хэвлэлийн хүрээлэн зэрэг байгууллагуудаас гадна “Глоб Интернэшнл” тэргүүтэй төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагын оролцоо их болж буй хэрэг юм. Ялангуяа “Глоб Интернэшнл” ТББ онцгойлон анхааран ажиллаж байгааг сайшаалтай. Төрийн зүгээс анхаардаггүйн шалтгааныг “Ямар ч засгийн газар хэвлэлийн эрх чөлөөг дэмждэггүй, үйлдэл нь ч ялгаагүй байдаг”¹¹-тай холбон үзэж болох юм. Дээр нэгэнт дурдсанчлан, цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлавал хэвлэлийн эрх чөлөөний индекс буурах төдийгүй, иргэний сэтгүүл зүйн хөгжил зогсонги байдалд орох аюултай. Тийм ч учраас иргэний сэтгүүл зүйг хөгжүүлэхийн тулд интернэтэд хязгаар хяналт тавихгүй байх нь чухал юм. Өнгөрсөн онд батлагдсан цахим сэтгэгдлийг шүүлтэнд оруулах арга хэмжээ нь хүмүүсийг соёлгүй гаж үг хэллэгийг хорих алхам байсан ч үүнийг зогсоох сайн арга биш юм. Харин ч эсрэгээр улам гааруулах хандлага ажиглагдсаныг бид ажиглалт судалгааны явцад анзаарлаа. Тухайлбал, “янхан”, “хужаа” гэх мэт үгсийг шүүлтийн программ ашиглаж буй сайтуудад “я.н.х.а.н” гэж бичээд ард нь “та нар ингээд бичүүлэхгүй бай за юу” гэх зэргээр дайрч давшилсан сэтгэгдэл олон байв. Энд харагдаж байгаа нэгэн

¹⁰МУИС. “Сэтгүүл зүй” эрдэм шинжилгээний бичиг. УБ 2010.х.55

¹¹Наранжаргал Х. “Хэвлэлийн эрх чөлөө Монголд” илтгэл УБ 2013

зүйл нь хамгийн гол нь иргэдэд, цахим эрх чөлөөний үнэ цэнийг ойлгуулан ухамсарлуулах ёс зүйн асуудал гарч ирж байгаа юм.

Иргэдийн цахим орчинд сэтгэгдэл үлдээх, үзэл бодлоо илэрхийлэхэд хөшүүрэг болж буй бас нэгэн чухал зүйл бол нэрээ нууцлах эрх юм. Иргэд нийгэмд чиглэсэн өөрсдийн шүүмжлэлээ сэтгэгдлээр илэрхийлэхдээ нэрээ нууцлах нь элбэг байдаг. Учир нь “шүүмжлэл сөрөг үзэл санаа гол төлөв сөрөг байдаг учир эрсдэл дагуулдаг¹². Мөн үзэл бодлоо илэрхийлснийхээ төлөө аюул заналхийлэлд өртөх магадлал их байдагтай холбоотой. Чухам энэ л эрх иргэд цахим орчинд сэтгэгдлээр дамжуулан төрийн өмнөөс хүчтэй дуугарч зөв зүйтэй шийдвэр гаргахад нөлөөлж байгаа юм.

Бид нөхцөл байдлыг илүү бодитоор үнэлэх, бүтээлч эрэл хайгуул хийх үүднээс интернэт хамгийн идэвхтэй ашигладаг нийгмийн бүлэг гэж болох 100 оюутны дунд бичил судалгаа \санал асуулга\ явуулсан юм. Судалгаагаар нийт оюутнуудын 86 хувь нь цахим орчинд өөртөө хяналт тавьдаг гэж гэж хариулсан бол үлдсэн хэсэг нь хяналт тавих шаардлагагүй гэж хариулжээ. Харин “Та цахим орчинд нэрээ нууцалдаг уу?, тэгэх шаардлага гардаг уу? гэсэн асуултанд 91 хувь нь тийм гэж хариулсан бол бусад нь тэгэх шаардлагагүй гэсэн байр сууриа илэрхийлсэн байна. Мөн “Монголд цахим эрх чөлөө олон улсын түвшинд хүртлээ баталгаажсан уу?” гэж асуухад 53 хувь нь тийм, 41 хувь нь үгүй гэсэн бол 6 хувь нь хэлж мэдэхгүй байна гэжээ. Эндээс үзэхэд цахим сэтгэгдэл үлдээж, мөн интернэтэд чөлөөтэй харилцаж байгаа хүмүүс нэрээ нууцлах нь түгээмэл байдаг нь ажиглагдаж байна.

Түүнчлэн бичих гэж буй зүйлээ эргэцүүлж нэг харан, тунгааж нэг бодож өөртөө хяналт тавьдаг болох нь илэрхий байна.

Монголын цахим сэтгүүл зүй, иргэний сэтгүүл зүйн хөгжил ямархуу түвшинд байна вэ?. Иргэний сэтгүүл зүйн хөгжилд цахим хэвлэл, тэр дундаа сэтгэгдэл ямар үүрэг гүйцэтгэж байна вэ?.

¹² Наранжаргал Х. “Цахим эрх чөлөө ба нэрээ нууцлах эрх” илтгэл УБ 2013

Нэг. Монголд иргэний сэтгүүл зүй боломжийн хэмжээнд хөгжиж байна. Иргэд сонинд захидал бичдэг уламжлалт хэв маяг хөгжлийн явцад өөрчлөгдөн цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх, сэтгэгдэл үлдээх шинэ алхамд шилжсэн байна.

Хоёр. Иргэд цахим орчинд сэтгэгдэл үлдээх, нийтлэл бичих нь элбэгшиж байна. Гэвч нийтийн хэм хэмжээг үл хүндэтгэж, хараалын үг хэрэглэн бүдүүлэг хандсанаас болж энэ эрх чөлөөг төрөөс хязгаарлаж эхэлсэн нь болгоомжлол төрүүлж байна. Өөрөөр хэлбэл, дараагийн авах арга хэмжээ нь юу байхыг таахын аргагүй эрсдэлтэй байдал бий болжээ. Хэрвээ төрөөс хязгаарлалт хийвэл бидний үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө багасаж, тэр хэмжээгээр иргэний сэтгүүл зүйн хөгжил “чөдөрлөгдөх” аюултай байна.

Гурав. Иргэд интернэт орчинд иргэд үзэл бодлоо илэрхийлэхдээ нэрээ нууцлах эрхээ эдэлж байна. Ерөнхийдөө сөрөг, шүүмжлэлт мэдээлэл түгээх бичих үедээ нэрээ нууцалдаг болох нь харагдлаа. Мөн цахим орчинд өөртөө тодорхой хяналт тавьдаг байна.

Дөрөв. Вэб сайтуудад гарч буй хэл найруулгын алдаатай болоод агуулгын хувьд зөрчилтэй, учир дутагдалтай материалуудыг редакцийн газар анхааралдаа авч хянан засварлах, контентынхоо чанарыг дээшлүүлэхэд шүүмжлэлт сэтгэгдэл онцгой үүрэг гүйцэтгэж байгааг цохон тэмдэглэе. Энэ нь иргэдийн цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх боломж бололцооны ачаар, сэтгүүл зүйн чанарт ахиц дэвшлийг өгч байгаагийн илрэл билээ. Үүнийг дагаад, иргэний сэтгүүл зүй, эрэн сурвалжлах сэтгүүл зүй “цэцэглэж” байна.

Тав. Дэлхийн зарим улс орнуудад иргэд нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөгүй байдаг. Гэтэл манай улсад энэ эрхийнхээ үнэ цэнийг ойлгохгүй, бусдыг гүтгэн доромжлох, нэр төрд нь халдах байдал ажиглагдаж байна. Энэ нь нэг талаар иргэдийн ухамсар, ёс зүйг дээшлүүлэх асуудал болон гарч ирж байна.

Зургаа. Иргэд цахим орчинд иргэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлснээрээ өөрийнхөө эрхийг эдлэх, цаашлаад сэтгүүл зүйн хөгжилд ахиц дэвшлийг үзүүлж байна. Хэдийгээр Монгол улсад цахим эрх чөлөө олон улсын хэмжээнд хүртлээ төгс баталгаажаагүй ч иргэдийн идэвхи оролцоо сайн байна” гэсэн дүгнэлтүүдийг хийж болох юм.

Бид цахим орчинд сэтгэгдлээр дамжуулан иргэний сэтгүүл зүй хөгжиж байгааг харуулсан судалгаандаа нэрээ нууцлах эрх эдлэх, цахим эрх чөлөөний асуудал зэргийг нарийвчлан харуулахыг оролдлоо. Мөн олон улсын жишиг, хүмүүсийн үзэл бодол зэргийг аль болохоор өргөн хүрээнд хамруулан авч үзэв. Эндээс нэг л зүйл хамгийн чухал. Тэр нь мэдээж цаашид цахим орчинд иргэний сэтгүүл зүйг яаж илүү сайн хөгжүүлэх, хууль эрх зүйн орчинг хэрхэн боловсронгуй болгох талаарх дүгнэлт зөвлөмж байх учиртай. Цаашдын хөгжлийн чиг хандлагыг хэрхэн тодорхойлох вэ?. Ямар зүй зохистой гаргалгаа, зөвлөмжийг өгөх вэ?.

Нэгдүгээрт, Цахим орчинд иргэдийн үг хэлэх эрхийг илүү сайн баталгаажуулж өгөх хэрэгтэй. Ингэснээр иргэний сэтгүүл зүй илүү сайн хөгжих бат суурь нь болж өгнө. Хэрэв сэтгэгдэл дэх үгсийг хориглосонтой адил алхмыг Засгийн газраас хийвэл сэтгүүл зүйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд тэмцэх, аль болох ашигтай байдлаар шийдвэрлэх байдлаар эвлэлдэн хэлэлцэх хэрэгтэй. Мөн иргэдийн идэвхи оролцоо хамгийн чухал юм.

Хоёрдугаарт, хууль эрх зүйн орчинг сайжруулах шаардлагатай. Иргэд цахим орчинд хэн нэгний алдаа дутагдлыг илчилснийхээ төлөө хариуцлага, ял хүлээх болоод байна. Манай улсад гүтгэлэг, доромжлолыг гэмт хэрэг гэж үздэг нь иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэхэд нь саад хаалт болж байна. Үүнээс үүдээд иргэний сэтгүүл зүйн хөгжил зогсонги байдалд орох аюултай байна. Мөн хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулинд мэдээллийн нууц эх сурвалжийг хамгаалах тухай заалт байдаггүй. Ингэснээр сэтгүүлчдийг дарамтлах, яллах гэж сүрдүүлснээс эрэн сурважлах сэтгүүл зүйн хөгжил ч “царцах” эрсдэлтэй байгаа юм. Иймд хэвлэлийн эрх чөлөөний хуулийн шинэчилсэн найруулгыг нэн даруй хэлэлцэн батлах, эрүүгийн хуулийн 110, 111 дүгээр заалтыг халах хэрэгтэй байна.

Гуравдугаарт, сэтгүүл зүйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд хамтарч ажиллах нь зүй. Ингэснээр мэдээллийн нийгмийн, сэтгүүл зүйн салбарын алдаа дутагдлыг засч засруулах хүч нь нэмэгдэнэ. Ялангуяа эрх зүйн зохицуулалт болон бодлогын чиг баримтлалаа хамтран боловсруулбал үр дүн нь тодорхой хэмжээгээр нэмэгдэнэ.

Дөрөвдүгээрт, өнөө үед интернэтийн хамгийн идэвхтэй хэрэглэгчид болох залуусын цахим эрх чөлөө, нэрээ нууцлах эрхийнх нь талаар сэтгүүл зүйн чиглэлээр ажиллдаг байгууллагуудаас сургалт семинар зохион байгуулах шаардлагатай гэж үзлээ. Мөн цахим орчинд сэтгэгдэл бичин үзэл бодлоо илэрхийлснээрээ нэг талаар өөрийн эрхийг эдэлж буй хэрэг, нөгөө талаар иргэний сэтгүүл зүйг хөгжүүлэхэд гар бие оролцож буй ухамсарт үйлдэл гэдгийг нь ойлгуулж өгөх нь зүйтэй.

Тавдугаарт, Цахим эрх чөлөөгөө эдэлж интернэт орчинд үзэл бодлоо илэрхийлэхдээ бусдыг гүтгэж доромжлохгүй, хүлээцтэй тэвчээртэй хандахын чухлыг иргэдэд ойлгуулах, энэ талаар төр засгаас ч анхаарлаа хандуулж өгвөл нэн сайн. Түүнчлэн, энэ эрхээ эдэлж чадахгүй маш олон орон байдаг гэдгийг бодит жишээгээр харуулах, бид ёс зүйтэй соёлтой байж чадахгүй бол дуу хоолойг нь хаах эрх мэдэл төр засагт бий гэдгийг ойлгуулах хэрэгтэй. Ингэхдээ залуусын дунд энэ чиглэлийн маргаан мэтгэлцээн өрнүүлэх, нийгэмд чиглэсэн реклам бэлдэж хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр тогтмол нэвтрүүлбэл үр дүнгээ өгнө гэсэн санааг бид дэвшүүлэн гаргаж байна. Хамгийн чухал нь төрөөс залуусаа дэмжих, залуусын хүчээр хийж болохуйц эдгээр ажлуудыг гардан гүйцэтгэхэд нь дэмжлэг үзүүлэх, урамшуулбал үр дүнтэй байх болно.

Бидний дэвшүүлж буй дээрх саналууд практикт хэрэгжвэл цахим эрх чөлөө улам баталгаажиж, иргэний сэтгүүл зүй хөгжих нь дамжиггүй юм. Ингээд “Интернэтийг цагдан хорих ямар ч боломж үгүй. Эрт, орой хэзээ нэг цагт үг хэлэх эрх чөлөө ялах болно” гэсэн Билл Гэйтсийн үгээр өгүүллээ өндөрлөө.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Азийн хэвлэл мэдээллийн барометр. УБ 2012
2. Болд-Эрдэнэ Б. Интернэт сэтгүүл зүй. УБ 2009
3. “Глоб Интернэшнл” ТББ Хэвлэлийн эрх чөлөөний тайлан УБ 2011
4. Зулькафиль М. Орчин үеийн сэтгүүл зүй. УБ 2009
5. Монголын хэвлэлийн хүрээлэн. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн мониторингийн судалгаа. УБ 2013
6. МУИС. “Сэтгүүл зүй” эрдэм шинжилгээний бичиг. УБ 2010

7. Наранжаргал Х. “Хэвлэлийн эрх чөлөө Монголд” илтгэл УБ 2013
8. Наранжаргал Х. “Цахим эрх чөлөө ба нэрээ нууцлах эрх” илтгэл УБ 2013
9. Норовсүрэн Л. Энхтуяа Х. Иргэний сэтгүүл зүй. УБ 2005
10. Цэрэнжав Д. “Интернэт, олон нийтийн өргөн нэвтрүүлэг, иргэний нийгмийн оролцоо” илтгэл. УБ 2013
11. www.globeinter.org.mn
12. www.securitylab.ru
13. www.legalinfo.mn
14. www.facebook.com\Найз групп
15. www.un.org

Ишлэл

1. ¹ Азийн хэвлэл мэдээллийн барометр. УБ 2012.х.10
2. ¹ Болд-Эрдэнэ Б. Интернэт сэтгүүл зүй. УБ 2009.х.9
3. ¹ Зулькафиль М. Орчин үеийн сэтгүүл зүй. УБ 2009.х.21
4. ¹ Монголын хэвлэлийн хүрээлэн. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн мониторингийн судалгаа. УБ 2013.х.1
5. ¹ МУИС. “Сэтгүүл зүй” эрдэм шинжилгээний бичиг. УБ 2010х.55
6. ¹ Монгол улсын үндсэн хууль
7. ¹ МУИС. “Сэтгүүл зүй” эрдэм шинжилгээний бичиг. УБ 2010.х.55
8. ¹ Наранжаргал Х. “Хэвлэлийн эрх чөлөө Монголд” илтгэл УБ 2013
9. ¹ Наранжаргал Х. “Цахим эрх чөлөө ба нэрээ нууцлах эрх” илтгэл УБ 2013
10. ¹ Норовсүрэн Л. Энхтуяа Х. Иргэний сэтгүүл зүй. УБ 2005.х.5
11. ¹ Цэрэнжав Д. “Интернэт, олон нийтийн өргөн нэвтрүүлэг, иргэний нийгмийн оролцоо” илтгэл. УБ 2013
12. www.securitylab.ru/news/215636.php

Өгүүллийн хураангуй

Тус өгүүлэлд Монголд цахим эрх чөлөө ямар түвшинд байгаа, тэр дундаа иргэний сэтгүүл зүй үүгээр дамжин хэрхэн хөгжиж буйг ажиглалтын болон анкетын, анализ-синтезийн аргаар задлан шинжилж нэгтгэн дүгнэсэн болно.

Манай улсад интернэт сайн хөгжиж, цахим орчинд иргэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж байгаа хэдий ч бие биедээ хүндэтгэлтэй хандах ёс зүйн асуудал урган гарч ирж байгаа юм. Мөн иргэд ялангуяа сэтгэгдлээр дамжуулан үзэл бодлоо илэрхийлж байгаа нь иргэний сэтгүүл зүй хөгжиж байгаагийн бодит илрэл болж байна.